



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2007 оны 01 дугаар
сарын 08 -ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Санхүүгийн хяналт шалгалтын газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулах ажлыг зохион байгуулахыг Санхүүгийн хяналт шалгалтын газар /Ч.Баттогтох/-т даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/47 дугаар захирамжийн 1, 2, 3 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны
17-дугаар захирамжийн хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Санхүүгийн хяналт шалгалтын газар нь /цаашид "газар" гэх/ Санхүүгийн улсын хяналт шалгалтын дүрмийг мөрдлөг болгон Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд санхүүгийн хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий орон нутгийн хяналтын байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тогтоол, шийдвэр, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь Нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.4. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж, чөлөөлнө.

1.5. Газрын дарга нь эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана.

1.6. Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

1.7. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.8. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батлана.

Хоёр. Газрын үүрэг

2.1. Газар нь Монгол улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

2.3. Газар нь Монгол улсын Төсвийн тухай хууль болон санхүү, бүртгэл тооцооны холбогдолтой бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.

2.4. Төрийн өмчийн болон төсвийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, ашиглалт зарцуулалтанд шалгалт хийж, шалгалтын дүнгээр гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулах.

2.5. Хяналт шалгалт хийсэн байгууллага, аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийн нууцыг зохих хууль тогтоомжийн дагуу чанд хадгалах.

2.6. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр нийслэлийн засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах.

2.7. Байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

2.8. Эрхэлж буй ажлын хүрээнд холбогдох зайлшгүй шаардлагатай асуудлаар асуудал боловсруулан Засаг даргад оруулж шийдвэрлүүлэх.

Гурав. Газрын эрх

3.1. Газар нь Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харъяа газар, нийслэл, дүүргийн төсөвтэй харьцдаг болон нийслэлийн өмчийн байгууллагуудад санхүүгийн баримтын шалгалтыг батлагдсан төлөвлөгөө графикийн дагуу хийнэ.

3.2. Харъяа байгууллагуудын удирдах албан тушаалтныг томилоход санал өгөх, тэдний ажлын талаар санал дүгнэлт гаргах.

3.3. Харъяа байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах, тэдгээрийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт оруулж шийдвэрлүүлэх.

3.4. Харъяа байгууллагуудын үйл ажиллагааны жил, хэтийн зорилт, төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, газрын батлагдсан төсвийг захиран зарцуулж тайлагнах.

3.5. Хууль тогтоомж зөрчин улс, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд учруулсан хохирлыг төлүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох талаар холбогдох арга хэмжээг авах.

3.6. Газар нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн хяналт шалгалтын дүрмийн болон холбогдох хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэлтийг хангуулах.

3.7. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.8. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдэлнэ.

-----oOo-----